



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Өргөн сэлэнгэ үйлчилгээ" ААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/25/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.selenge@audit.gov.mn

Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: А.Гэрэлмаа

Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НБББББ	Нягтлан болох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОУХТ	Олон улсын худалдааны төв
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
3.Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	14
4. Аудитын тайлан	15
4.1. Ерөнхий зүйл.....	15
4.2. Материаллаг байдал.....	16
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.3.1 Шилэн дансны мэдээлэл	16
4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. Аудитын илрүүлэлт.....	20
5.1 Залруулга	20
5.2 Төлбөрийн акт	
5.3 Албан шаардлага.....	
5.4 Зөвлөмж	
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	22



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“ӨРГӨН СЭЛЭНГЭ ҮЙЛЧИЛГЭЭ”
ААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
И.ЧУЛУУНБОЛД ТАНАА

2023.02.15 № СЭА-2023/25-НА-СТА-ОНА

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Өргөн сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн нөлөөг эс тооцвол “Өргөн сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтгүйгээр шатахууны зардал гаргасан, эд хариуцагч солигдоход хөрөнгийн тооллого хийгээгүй зэрэг зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь тайлант онд 765,868.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,215,403.1 мянган төгрөгийн зардал гарган, 449,534.8 мянган төгрөгийн алдагдалтай тайлагнагдсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд ажил, үйлчилгээний нийт орлогыг 547,978.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 765,868.3 мянган төгрөг төвлөрүүлэн, төлөвлөгөөг 39.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Нийт зардлыг 539,333.6 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,215,403.1 мянган төгрөгийн зардал гаргаж, төлөвлөгөөг 673,668.2 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан



Мөрийн дугаар	Үзүүлэлт	1/1/2022	12/31/2022
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	109,025,949.99	6,711,541.52
1.1.2	Дансны авлага	138,082,907.84	83,436,757.50
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		
1.1.4	Бусад авлага	5,181,210.00	5,181,210.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	210,797,043.69	280,256,956.29
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
	Эргэлтийн хөрөнгийн дүн	463,087,111.52	375,586,465.31
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	6,115,976,652.91	8,349,003,311.56
1.2.2	Биет бус хөрөнгө	285,613,242.70	285,575,592.10
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,401,589,895.61	8,634,578,903.66
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,864,677,007.13	9,010,165,368.97
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	88,647,491.26	4,103,080.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	86,826,566.25	265,124,870.10
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	175,474,057.51	269,227,950.10
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	175,474,057.51	269,227,950.10
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	8,130,662,473.02	10,816,142,859.02
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,441,459,523.40)	(2,075,205,440.15)
2.3.11	Эздийн өмчийн дүн	6,689,202,949.62	8,740,937,418.87
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	6,864,677,007.13	9,010,165,368.97



2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)		765,233,821.87
2	Борлуулалтын өртөг		2,401,289.09
3	Нийт ашиг(алдагдал)	-	762,832,532.78
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал		1,213,001,793.66
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		634,500.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-	(449,534,760.88)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-	(449,534,760.88)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(449,534,760.88)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	-	(449,534,760.88)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 03-р сарын 31-ний үлдэгдэл		-		8,130,662,473.02	(1,441,459,523.40)	4317143998 6,689,202,949.62
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						-
3	Залруулсан үлдэгдэл				8,130,662,473.02	(1,441,459,523.40)	6,689,202,949.62
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)						-
5	Бусад дэлгэрэнгүй орлого						-
6	Өмчид гарсан өөрчлөлт						-
7	Зарласан ногдол ашиг						-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
9	2022 оны 09 -р сарын 30-ний үлдэгдэл	-	-	-	8,130,662,473.02	(1,441,459,523.40)	6,689,202,949.62
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					(184,211,155.87)	(184,211,155.87)
11	Залруулсан үлдэгдэл	-			8,130,662,473.02	(1,625,670,679.27)	6,504,991,793.75
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					(449,534,760.88)	(449,534,760.88)
13	Бусад дэлгэрэнгүй орлого						-
14	Өмчид гарсан өөрчлөлт				2,685,480,386.00		2,685,480,386.00
15	Зарласан ногдол ашиг						-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
17	2022 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	-	-	-	10,816,142,859.02	(3,700,876,119.42)	8,740,937,418.87

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/
 47707
 916,193,878.78
 964,514,287.25
 53,994,000.00
 109,025,949.99
 109,025,949.99

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		4317143998
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	916,193,878.78
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		570,113,878.78
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		346,080,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	964,514,287.25
1.2.1	Ажиллагчдад төлсөн		184,631,023.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		71,905,986.61
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн		342,099,992.29
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн		271,793,311.51
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		68,481,340.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн		11,433,747.84
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага		14,168,886.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(48,320,408.47)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	53,994,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		53,994,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(53,994,000.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-	(102,314,408.47)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	109,025,949.99	109,025,949.99
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	109,025,949.99	6,711,541.52

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2022 оны		Зөрүү	хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	Орлогын нийт дүн	547,978.0	765,868.3	217,890.3	39.8%
1	Татаас, санхүүжилт /Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг/	59,978.0	346,080.0	286,102.0	477.0%
2	ОУХТөв түрээсийн орлого	422,000.0	359,518.4	(62,481.6)	-14.8%
3	Мал нядалгааны орлого	20,000.0	21,489.0	1,489.0	7.4%
4	Сайханы хөтөлийн орлого	18,000.0	19,314.9	1,314.9	7.3%
5	Журмын хашааны түрээсийн орлого	-	7,540.8	7,540.8	
6	Нийтийн тээврийн орлого	13,000.0	2,639.8	(10,360.3)	-79.7%
7	Бусад орлого	15,000.0	9,285.5	(5,714.5)	-38.1%
	Нийт зардлын дүн	539,333.6	1,215,403.1	(676,069.4)	-125.4%
1	Цалин хөлс болон нэмэгдэл цалин	157,122.9	156,462.5	(660.4)	-0.4%
2	Нэмэгдэл урамшил	35,165.1	59,210.3	24,045.2	68.4%
3	Хоол, унааны зардал	18,900.0	22,325.0	3,425.0	18.1%
4	Нийгмийн даатгал шимтгэл	30,622.3	34,621.5	3,999.2	13.1%
5	Гэрэл цахилгаан	66,422.5	129,980.4	63,557.8	95.7%
6	Түлш, халаалт	82,000.0	46,911.0	(35,089.0)	-42.8%
7	Цэвэр бохир ус	14,000.0	15,818.2	1,818.2	13.0%
8	Бичиг хэрэг	1,497.5	2,965.8	1,468.3	98.1%
9	Тээвэр, шатахуун	54,543.2	50,810.6	(3,732.6)	-6.8%
10	Шуудан холбоо	2,220.0	112.0	(2,108.0)	-95.0%
11	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал, цэвэрлэгээ	6,912.0	11,188.6	4,276.6	61.9%
12	Маягт, үнэт цаас хэвлүүлэх зардал	-	2,565.1	2,565.1	
13	Дотоод албан томилолт	250.0	215.0	(35.0)	-14.0%
14	Аудитын төлбөр	2,500.0	2,000.0	(500.0)	-20.0%
15	Хөдөлмөр хамгааллын зардал	3,500.0	-	(3,500.0)	-100.0%
17	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,425.0	6,710.0	(715.0)	-9.6%
18	Урсгал засвар	5,355.5	123,168.5	117,813.0	2199.9%
19	Жижиг эд хогшил	4,500.0	4,000.0	(500.0)	-11.1%
20	Биеийн тамир уралдаан, тэмцээн	7,400.0	-	(7,400.0)	-100.0%
21	Төлбөр хураамж татвар	7,965.1	19,033.4	11,068.4	139.0%
22	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99.0	231.0	132.0	133.3%
23	Тээврийн хэрэгслийн татвар	238.5	6.3	(232.2)	-97.3%
24	Сэлбэг, материалын зардал	9,250.0	-	(9,250.0)	-100.0%
25	Үл хөдлөх хөрөнгийн татвар	17,545.1	17,545.1	0.0	0.0%
26	Банкны шимтгэл	-	136.2	136.2	
27	Ахмад настнуудад олгосон тэтгэмж	1,400.0	-	(1,400.0)	-100.0%
28	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	2,500.0	500.0	(2,000.0)	-80.0%
29	Элэгдлийн зардал	-	506,485.4	506,485.4	
30	Үндсэн хөрөнгийн данснаас хассаны олз гарз	-	-	-	
31	ББӨ	-	2,401.3	2,401.3	
	Ашиг, алдагдал	8,644.4	(449,534.8)	891,558.5	10313.8%

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Өргөн сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ нь “Сүхбаатар сумын ард иргэдийг тэгш хүртээмжтэй, соёлч боловсон, түргэн шуурхай үйлчилгээгээр ханган ажиллах” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

“Өргөн сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Худалдааны төвийн тохижилт, түүний орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг хариуцан гүйцэтгэх, хяналт тавих, батлагдсан төсөв, зардлын хүрээнд зарцуулалт хийх, үр ашигтай ажиллуулах,
- Худалдааны төвд үйл ажиллагаа явуулах иргэн, байгууллагатай гэрээ хийх, байр талбайг ашиглуулах, ашиглалтын төлбөр тооцоог хийх,
- Орон нутгийн өмчийн тээврийн хэрэгслээр аймгийн төвд эрх бүхий байгууллагын тогтоосон чиглэл, хуваарь, үнэ тарифаар нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх, төсвийн байгууллагад захиалгат үйлчилгээг тогтоосон үнэ тарифаар үзүүлэх,
- Орон нутгийн өмчийн мал нядалгааны цэг, махны хөргүүрт зоорины ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг хариуцан гүйцэтгэх,
- Эрх бүхий байгууллага албан тушаалтны шийдвэрийн дагуу аймгийн махны нөөцийг бүрдүүлэх, хадгалах, түгээх ажил үйлчилгээг эрхлэх,
- Сүхбаатар сумын нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлэг, түүний засвар үйлчилгээг хариуцан гүйцэтгэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал буюу төлөөлөн хэрэгжүүлэгч нь сумын Засаг дарга байх бөгөөд 100 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Сүхбаатар сумын ИТХ-ын 2022 оны 37 дугаар тогтоолоор “Сүхбаатар хөгжил, тохижилт” ОНӨААТҮГ-ыг татан буулгасан бөгөөд тус сумын ИТХ-ын 2022 оны 38 дугаар тогтоолоор “Өргөн сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-г байгуулсан байна. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-д “Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно”, 22 дугаар зүйл “Сумын чиг үүрэг”, 22 дугаар зүйлийн 22.1.13 дахь “нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрэн, ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалт”, 22.1.21 дэх “суурин газрын гэрэлтүүлэг, арчлалт”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах,

захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Тус байгууллагад Төлөөлөн удирдах зөвлөл байхгүй болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсэн,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн гэх мэт.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Өргөн сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

“Өргөн сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлог тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Өргөн сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, татварын өр, эздийн өмчийн бусад хэсэг дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	109,025.9	6,711.5	(102,314.4)
Авлага	143,264.1	88,618.0	(54,646.2)
Татвар, НДШ-ийн авлага	-	-	-

Бараа материал	210,797.0	280,257.0	69,459.9
Үндсэн хөрөнгө	6,401,589.9	8,634,578.9	2,232,989.0
Нийт хөрөнгийн дүн	6,864,677.0	9,010,165.4	2,145,488.4
Өр төлбөр	88,647.5	4,103.1	(84,544.4)
Татварын өр	86,826.6	265,124.9	178,298.3
Эздийн өмчийн бусад хэсэг	8,130,662.5	10,816,142.9	2,685,480.4
Хуримтлагдсан ашиг/+, алдагдал/-	(1,441,459.5)	(2,075,205.4)	(633,745.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,864,677.0	9,010,165.4	2,145,488.4

Байгууллагын мөнгөн хөрөнгийн данс 6,711.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдаж, өмнөх оноос 102,314.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд касс болон харилцах дансаар 1,046,801.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,149,116.2 мянган төгрөгийг зарцуулснаас шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл 88,618.0 мянган төгрөг болж 54,646.2 мянган төгрөгөөр буурсан нь түрээсийн авлага буурснаас голлон шалтгаалсан байна. Нийт авлагын 42.8 хувийг буюу 37,944.6 мянган төгрөгийг түрээсийн авлага, 43.7 хувийг буюу 38,762.0 мянган төгрөгийг нөөцийн махны авлага, 7.5 хувийг буюу 6,607.2 мянган төгрөгийг ажиллагсдаас авах авлага, 5.9 хувийг буюу 5,181.2 мянган төгрөгийг бусад авлага, 0.1% буюу 123.0 мянган төгрөгийг байгууллагаас авах авлага эзэлж байна.

Авлагын үлдэгдэлд хугацаа хэтэрсэн, эзэн холбогдогч тодорхойгүй, насжилт өндөртэй нөөцийн махны 38,762.0 мянган төгрөгийн найдваргүй авлага байна.

Бараа материал дансны үлдэгдэл 280,257.0 мянган төгрөг болж өмнөх оноос 69,459.9 мянган төгрөгөөр өссөн нь өөрийн хөрөнгөөр 68,291.4 мянган төгрөгийн нөөцийн мах, 32,103.6 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, 5,490.9 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 50,810.6 мянган төгрөгийн түлш шатах тослох материал, 3,539.0 мянган төгрөгийн хангамжийн материал, 130,428.0 мянган төгрөгийн аж ахуйн материал худалдан авч, 221,203.6 мянган төгрөгийн бараа материалыг худалдан борлуулсан болон зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 2,739,474.4 мянган төгрөгөөр өссөн нь 2,739,474.4 мянган төгрөгийн дараах хөрөнгүүдийг хүлээн авч данс бүртгэлд тусгаснаас шалтгаалжээ. Үүнд:

- Өөрийн хөрөнгөөр 10,669.0 мянган төгрөгөөр тээврийн хэрэгслийг капиталжуулан бүртгэсэн,
- ОУХТ-ийн 1 давхарт 43,325.0 мянган төгрөгийн эйр кондейшн худалдан авсан,
- Замын сангийн хөрөнгө оруулалтаар 323,555.7 мянган төгрөгийн 7 гэрлэн дохио хийж гүйцэтгэсэн,
- Сумын хөрөнгө оруулалтаар 19,500.0 мянган төгрөгийн Hyundai Starex-TQ тээврийн хэрэгсэл, аймгийн хөрөнгө оруулалтаар 63,998.0 мянган төгрөгийн Hyundai Mighty маркийн автокран нийлүүлэгдсэн,
- Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар ОУХТ-ийн 2 давхарт 62,218.2 мянган төгрөгийн эйр кондейшн, хийгдсэн,

- Австри улсын хөрөнгө оруулалтаар “Дэд бүтцийн хөгжил” төслийн хүрээнд хийгдсэн 2,216,208.5 мянган төгрөгийн 800ш гэрэлтүүлэг гэх мэт.

Өр төлбөр дансны үлдэгдэл 4,103.1 мянган төгрөг болж 84,544.4 мянган төгрөгөөр буурсан нь цахилгааны 34,688.0 мянган төгрөгийн, халаалтын 38,810.1 мянган төгрөгийн, цэвэр бохир усны 1,979.4 мянган төгрөгийн, шатахууны 11,565.9 мянган төгрөгийн зэрэг өмнөх оны өр төлбөрүүдийг барагдуулснаас голлон шалтгаалжээ.

Татварын өр төлбөр 265,124.9 мянган төгрөг болж, 178,298.3 мянган төгрөгөөр өссөн нь татан буугдсан Сүхбаатар хөгжил тохижилт ААТҮГ-ын санхүүгийн тайланд татварын хяналт шалгалтаар тавигдсан 153,867.8 мянган төгрөгийн нөхөн татвар, торгууль, алданги, тайлант үед ногдуулсан 17,545.1 мянган төгрөгийн, үл хөдлөх эд хөрөнгийн, 5,158.0 мянган төгрөгийн ХХОАТ зэрэг татварын өр төлбөрүүд нэмэгдсэнээс голлон шалтгаалжээ.

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэл 10,816,142.9 мянган төгрөг болж 2,685,480.4 мянган төгрөгөөр өссөн нь аймаг, сумын болон замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэн тус байгууллагын бүртгэлд шилжүүлсэн дараах хөрөнгүүдийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэнээс шалтгаалсан байна. Үүнд:

- Сүхбаатар сумын гэрлэн дохио 323,555.7 мянган төгрөг,
- Hyundai Starex-TQ тээврийн хэрэгсэл 19,500.0 мянган төгрөг,
- Hyundai Mighty маркийн автокран 63,998.0 мянган төгрөг,
- ОУХТ-ийн 2 давхарт эйр кондейшн 62,218.2 мянган төгрөг,
- Австри улсын хөрөнгө оруулалтаар 800ш гэрэлтүүлэг 2,216,208.5 мянган төгрөг

Хуримтлагдсан ашиг/ алдагдал / дансны үлдэгдэл 2,075,205.4 мянган төгрөг болж, өмнөх оноос алдагдал 633,745.9 мянган төгрөгөөр өсөхөд тайлант үеийн үр дүн нөлөөлсөн байна.


3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Өргөн сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-ын гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Өргөн сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулсан боловч батлуулаагүй бөгөөд гүйцэтгэлээр 765,868.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,215,403.1 мянган төгрөгийн зардал гарган, 449,534.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Орлогыг дараах эх үүсвэрээс бүрдүүлжээ. Үүнд:

- Түрээсийн орлого 359,518.4 мянган төгрөг,
- Нийтийн тээврийн орлого 2,639.8 мянган төгрөг,
- Сайхны хөтлийн орлого 19,314.9 мянган төгрөг,



- Нядалгааны орлого 21,489.0 мянган төгрөг,
- Журмын хашааны орлого 7,540.8 мянган төгрөг,
- Бусад орлого 8,650.9 мянган төгрөг,
- Нийтийн тээвэр, гэрэлтүүлгийн татаас санхүүжилтийн орлого 141,080.0 мянган төгрөг,
- Сүхбаатар сумын төсвийн тодотголоор 205,000.0 мянган төгрөг зэрэг.

Тайлант онд Сүхбаатар сумын төсвийн тодотголоор 205,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмж олгосон бөгөөд гүйцэтгэлээр 135,926.6 мянган төгрөгийг зориулалтын дагуу, 69,073.4 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, төлөвлөсөн ажлуудын гүйцэтгэл бүрэн гараагүй байна.

№	Үзүүлэлт	олгосон санхүүжилт	гүйцэтгэл	Хэмнэлт, хэтрэлт
1	Гэрэлт цогцолборын засвар үйлчилгээнд	60,000,000.00	36,021,600.00	23,978,400.00
2	ОУХТөвийн дээврийн засварт	60,000,000.00	19,560,000.00	40,440,000.00
3	ОУХТөвийн 1 давхарт эйр кондейшн худалдан авахад	45,000,000.00	43,325,000.00	1,675,000.00
4	Төв талбай, ногоон байгууламжийн гэрэлтүүлгийн засвар үйлчилгээнд	20,000,000.00	17,020,000.00	2,980,000.00
5	Гэрэлтүүлгийн татаас санхүүжилт	20,000,000.00	20,000,000.00	-
		205,000,000.00	135,926,600.00	69,073,400.00

Үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 765,868.3 мянган төгрөг болж төлөвлөснөөс / төлөвлөгөөг батлуулаагүй / 217,890.3 мянган төгрөг буюу 39.8 хувиар давж биелсэн нь төсвийн тодотголоор татаас, санхүүжилтийн 205,000.0 мянган төгрөгийн орлого нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,213,001.8 мянган төгрөг болж, төлөвлөснөөс / төлөвлөгөөг батлуулаагүй / 673,668.2 мянган төгрөг буюу 124.9 хувиар хэтэрсэн нь төсвийн тодотголтой холбоотой урсгал зардал, элэгдлийн зардлаас /төлөвлөгөөнд элэгдлийн зардлыг тусгаагүй/ голлон шалтгаалсан байна.

Тайлант онд алдагдал 449,534.8 мянган төгрөг болж, төлөвлөснөөс өссөн нь цалингийн болон гэрэл цахилгааны зардал нэмэгдсэнээс шалтгаалсан байна.


Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Өргөн сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.



Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй болон төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбарын аудитор А.Гэрэлмаа гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Өргөн сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайланг “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбарт 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 24 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 2,727,281.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 27,272.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант хугацаанд “Өргөн сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ нь мэдээлбэл зохих 20 төрлийн 148 мэдээллээс 121 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбартай холбоотой мэдээллийг 15 удаа,
- Дараа жилийн төсвийн төсөлтэй холбоотой мэдээллийг 1 удаа,
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлттэй холбоотой мэдээллийг 10 удаа,
- Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлантай холбоотой мэдээллийг 1 удаа,
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээтэй холбоотой мэдээллийг 10 удаа,
- Санхүүгийн тайлантай холбоотой мэдээллийг 1 удаа,
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөтэй холбоотой мэдээллийг 1 удаа,
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг 11 удаа,
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлтэй холбоотой мэдээллийг 10 удаа,
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягтай холбоотой мэдээллийг 10 удаа,
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэлтэй холбоотой мэдээллийг 10 удаа,
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэртэй холбоотой мэдээллийг 10 удаа,
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлантай холбоотой мэдээллийг 1 удаа,
- Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлттэй холбоотой мэдээллийг 10 удаа,
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлттэй холбоотой мэдээллийг 10 удаа,
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнтэй холбоотой мэдээллийг 10 удаа гэх мэт.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд:

Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, холбогдох албан тушаалтнаар батлуулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж сумын Засаг даргаар батлуулж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн “Үүрэг чиглэл өгөх тухай” 01/634 дүгээр албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд үйлдвэрлэлийн үр дүнгээр өөрийгөө санхүүжүүлэн ажиллах нөхцөл боломжийг хэрэгжүүлэн алдагдалгүй ашигтай ажиллах бүхий л бололцоог ханган ажиллах, шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг заасан хугацаанд бүрэн мэдээлж байх, 2021 оны санхүүгийн тайланд өгсөн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн өглөг, авлагыг бууруулах зөвлөмжүүдийг хүргүүлсэн байна.

“Өргөн сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Түрээсийн авлагыг 60,292.1 мянган төгрөгөөр бууруулсан,
- Дансны өглөг 84,544.4 мянган төгрөгөөр бууруулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбарын 2022 оны 11 дүгээр 02-ны өдрийн 22/55 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус газрын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь тайлант онд шинээр үүсгэн байгуулагдсан тул өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж байхгүй болно.

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан “Өргөн сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-ын санхүүгийн тайлангийн аудитын явцад туслах үйл ажиллагааны орлогыг бүрэн гүйцэт мөшгин шалгах боломжгүй байсан учир дараагийн аудитаар нарийвчлан шалгах нь зүйтэй юм.

2. “Өргөн сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ нь Сүхбаатар сумын нийтийн тээвэр, гэрэлтүүлгийн ажлыг хариуцан хийдэг бөгөөд байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 9 тээврийн хэрэгслээс үйл ажиллагаанд хэвийн ашиглагдаж байгаа 3 тээврийн хэрэгсэл байна. 5 тээврийн хэрэгсэл нь тус байгууллагын өмчлөлд шилжээгүй, “Сэлэнгэ аймаг ТҮГ” эзэмшилтэй, 2022 оны техникийн үзлэг оношилгоонд тэнцээгүй, эвдэрсэн, үйл ажиллагаанд ашиглагдахгүй байна.

Улсын дугаар	Марк	тоо хэмжээ	өртөг	Өмчлөгч	Тайлбар
1682СББ	Пронтер	1	1,680,000	Тээврийн хэрэгслийн гэрчилгээгүй	2022 онд үзлэгт тэнцээгүй, эвдэрхий, ашиглаагүй байгаа.
1554СЭҮ	Huindai mayti /Маяти/	1	11,000,000	Сэлэнгэ аймаг ТҮГ	2022 онд үзлэгт тэнцээгүй, эвдэрхий, ашиглаагүй байгаа.
1712СЭҮ	Истана	1	13,200,000	Сэлэнгэ аймаг ТҮГ	2022 онд үзлэгт тэнцээгүй, эвдэрхий, ашиглаагүй байгаа.
6697СЭҮ	County	1	50,000,000	Сэлэнгэ аймаг ТҮГ	2022 онд үзлэгт тэнцээгүй, эвдэрхий, ашиглаагүй байгаа.
5906СЭА	Форд транзит	1	44,000,000	Сэлэнгэ аймаг ТҮГ	2022 онд үзлэгт тэнцээгүй, эвдэрхий, ашиглаагүй байгаа.
1851СЭҮ	Истана	1	22,000,000	Өргөн сэлэнгэ үйлчилгээ ААТҮГ	Нийтийн тээвэрт ашиглагдаж байна.
4212СЭА	Toyota Dyna /Өргөгч автокран/	1	8,050,400	Сэлэнгэ аймаг ТҮГ	Хуучин өргөгч автокраныг сэлбэж засварлан гэрэлтүүлгийн ажилд ашиглаж байна.
7053СБА	Hyundai Starex-TQ	1	19,500,000	Өргөн сэлэнгэ үйлчилгээ ААТҮГ	2022 онд аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр авсан нийтийн тээвэрт ашиглаж байна.
3175СЭН	Hyundai Mighty өргөгч автокран	1	63,998,000	Өргөн сэлэнгэ үйлчилгээ ААТҮГ	2022 онд аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр авсан, эвдэрсэн, ашиглаагүй байна.
Нийт дүн		9	233,428,400		

Тайлант онд аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн “Баян булагт тал” ХХК-ийн нийлүүлсэн өргөгч кран Hyundai Mighty маркийн автомашин нь ирснээс хойш 1 сар болоход 3 удаа эвдэрч сэлбэгийн зардал гарсан, одоогоор огт ажиллаагүй сул зогссон байдалтай байна.

Хуучин Toyota dyna автокранд 2,219.5 мянган төгрөгийн засвар үйлчилгээний зардал гарч сэлбэн засварласнаар одоо гэрэлтүүлгийн ажилд ашиглаж байна.

Аймаг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэн нийлүүлж буй тээврийн хэрэгслийн чанар байдалд үнэлэлт өгч, шаардлага хангасан хөрөнгө оруулалт хийх нь зүйтэй байна.

5. Аудитын илрүүлэлт

5.1 Залруулга

Аудитаар нийт 4,234,071.7 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Татварын тайланд 354,322.2 мянган төгрөгийн орлогыг тайлагнаагүй,
- Санхүүгийн байдлын тайланд бараа материалын тайлангаар дамжуулалгүй шууд зардлаар тайлагнаснаас 68,291.4 мянган төгрөгийн нөөцийн мах, 27,230.0 мянган төгрөгийн нормын хувцасны орлогыг дутуу тайлагнасан,
- Санхүүгийн байдлын тайланд хөрөнгө оруулалтаар хийгдсэн гэрэлтүүлгийн ажлын 2,216,208.5 мянган төгрөгийн хөрөнгийг тусгаагүй,
- НӨАТ салгаж бүртгээгүйгээс зардлын 2,528.2 мянган төгрөгийн, бараа материалын тайланд 1,679.3 мянган төгрөгийн мөнгөн дүнг зөрүүтэй тайлагнасан,
- Орлогын дэлгэрэнгүй тайланд орлогыг 23,821.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Орлогын дэлгэрэнгүй тайланд үндсэн хөрөнгийн ашиглах жилийг буруу тогтоосноос 1,195,162.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал илүү тайлагнасан,
- Орлогын дэлгэрэнгүй тайланд 167,441.1 мянган төгрөгийн татварын, 5,973.9 мянган төгрөгийн цалингийн өглөгийг бүртгэснээс 173,415.0 мянган төгрөгөөр зардал илүү тайлагнагдсан,
- Санхүүгийн байдлын тайланд 153,867.8 мянган төгрөгийн татварын акт, 17,545.1 мянган төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын өглөгийг тусгалгүй орхигдуулсан гэх мэт.

Аудитаар нийт **84,554.2** мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлснээс 2,870.0 мянган төгрөгийн нөхөн төлүүлэх төлбөрийн акт, 66,093.4 мянган төгрөгийн албан шаардлага, 15,590.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

5.2 Төлбөрийн акт

1. Жолоочийн тооцооны хуудас, маршрут зэрэг анхан шатны нотлох дэмжих баримтгүйгээр захирал И.Чулуунболдод 2,395.0 мянган төгрөгийн, нягтлан бодогч Л.Цолмончимэгт 475.0 мянган төгрөгийн, нийт 2,870.0 мянган төгрөгийн шатахуун олгож, бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.1-д "орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Албан шаардлага

1. Сүхбаатар сумын төсвийн тодотголоор гэрэлт цогцолборын засвар үйлчилгээнд 60,000.0 мянган төгрөг, ОУХТ-ийн дээврийн засварт 60,000.0 мянган төгрөг, 1 дүгээр давхрын эйр кондейшн худалдан авахад 45,000.0 мянган төгрөг, нийт 165,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос гүйцэтгэлээр 98,906.6 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэн, үлдэгдэл **66,093.4** мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн болон гэрэлтүүлгийн өмнөх оны өр төлбөрийг барагдуулж зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг тайлагнаж байх болон тус үйлдвэрийн газрын захирал И.Чулуунболдод сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэх.

2. Эд хариуцагч солигдоход эд хөрөнгийн тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулж ажил хүлээлцээгүй, хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгээгүй, тооллогод хамруулаагүй, бараа материалаар бүртгэгдэх хөрөнгүүдийг үндсэн хөрөнгөд бүртгэснээр элэгдлийн зардлыг илүү тооцсон зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл 12.2 дахь “*Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ*”, 12.2.2 дэх “*эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед*”, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх...*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Эд хөрөнгийн тооллогыг чанартай, үнэн зөв хийж байх, хууль тогтоомжийг мөрдөн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

5.4 Зөвлөмж

1. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1 Илрүүлэлт: Тайлант онд 15,590.8 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

2.1 Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь “*Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж,*

байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 8.1.5 дахь “санхүүгийн тайлангийн тодруулга” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2 **Өгсөн зөвлөмж:** Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг хийж байх.

3. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

2.1 **Илрүүлэлт:** Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 8.1.5 дахь “санхүүгийн тайлангийн тодруулга” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2 **Өгсөн зөвлөмж:** Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг хийж байх.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Татварын тайланд борлуулалтын орлогыг дутуу тайлагнасан	1	354,322.2	1	354,322.2			1	354,322.2				
Бараа материалыг шууд зардлаар тайлагнасан	1	95,521.4			1	95,521.4	1	95,521.4				
Үндсэн хөрөнгө бүртгээгүй, тооллогод хамруулаагүй	1	2,216,208.5	1	2,216,208.5			1	2,216,208.5				
НӨАТ салгаж бүртгээгүй	1	4,207.5			1	4,207.5	1	4,207.5				
Орлогыг дутуу тайлагнасан	1	23,821.5			1	23,821.5	1	23,821.5				
Элэгдлийн зардлыг илүү тайлагнасан	1	1,195,162.1			1	1,195,162.1	1	1,195,162.1				
Орлогын тайланд зардал илүү тайлагнасан	1	173,415.0			1	173,415.0	1	173,415.0				
Санхүүгийн тайланд татварын өглөгийг тусгаагүй	1	171,412.9			1	171,412.9	1	171,412.9				
Дүн	8	4,234,071.1	2	2,570,530.7	6	1,663,540.4	8	4,234,071.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал		
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Тоо	Дүн	Тоо	Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн					Тоо
Нотлох, дэмжих баримтгүй шатахуун зарцуулсан	1	2,870.0	1	2,870.0									
Төсвийн санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан	1	66,093.4			1	66,093.4							
Эд хөрөнгийн тооллого хийгээгүй	1	-			1	-							
Худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй	1	15,590.8					1	15,590.8					
Санхүүгийн тайлангийн тодруулгыг иж бүрэн хийгээгүй	1	-					1	-					
Албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлсэн									1				
Дүн	6	84,554.2	1	2,870.0	2	66,093.4	2	15,590.8	1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон	121							121	
Огт мэдээлээгүй									
Дүн	121							121	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулаагүй	1	-			1	-			
Дүн	1	-			1	-		121	
Нийт дүн	122				1			121	